



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЧАНДМАНЬ-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 09 сарын 13 өдөр

Дугаар А/67

Хөхөө

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дүгээр тушаалын 1.5, 2.7 дахь заалт, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл авсан иргэд болон жижиг дунд үйлдвэр эрхлэгч нарыг сургалтад хамруулах үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнээ сурталчилах худалдан борлуулахад дэмжлэг болох 550000/ Таван зуун тавин мянга/ төгрөгийг олгосугай.

2.Дээрх зарцуулагдах 550,000(Таван зуун тавин мянга) төгрөгийг Хоршоо хөгжүүлэх сангийн хүүний орлогоос олгохыг Нягтлан бодогч (Д.Баяржаргал)-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Баасанжав)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Л.ЭНХЖАРГАЛ

